

СОЛОНГОСЫН ТӨР УЛС ҮҮССЭН ТУХАЙ ДОМОГ ЗОХИОЛЫН СУДАЛГАА

Суншил Их Сургуулийн Хэл уран зохиолын сургууль багш Жан Гён Нам

Abstract: Even the legend of Tangun, legend of Jumuny, and Kim Su Ru are representation of Korean Nations and it's well-known that the top of the legend of founding Korean state. It has been translated from these explanation researches about the legend of the founding Korean state by Jan Gyon Nam, Korean ancient literature teacher of Soongsil University. It is translated by adding note from this researching work.

Домог нь алив юмсын эх үндсийг тайлан тайлбарлах шинжтэй бөгөөд дэлхий ертөнц ба хүн төрөлхтний гарал үүсэл, орчин тойрон, төр улс, улс түмний үнэт зүйлс ба соёлын талаар өгүүлдэг. Домогзүйн нийтлэг төрх тэнгэрээс гаралтай, тэнгэрлэг чанарыг онцлон харуулдаг.

Солонгос домог үлгэр нь бичгээр болон амаар уламжлагджээ. Судлаачид эхэндээ бичгийн сурвалжийг түлхүү судалж байгаад хожим ам дамжсан домог зохиолыг судлах болсон байна. Солонгос домог үлгэрийн цар хүрээг ядмаг гэж үзэх нь судалгааны дээрх хандлагаас үүдэлтэй. Аман домог нь бөө мөргөлийн жүжигчилсэн хэлбэрээр тархсан учраас энгийн хүмүүсийн сонирхол бодит байдлаас холдсон нь тодорхой.

Солонгос домгийг агуулга, соёлын онцлог, уран сайхны хэлбэр, уламжлалт хэв ёс, цар хүрээгээр нь баатарлагийн, төр улсыг үүсгэн байгуулсан, газар тариалангийн, ертөнцийн гарал үүслийн домог гэж ангилсан байдаг. Мөн домгийг уламжлалыг баримтлан төр улс үүсгэн байгуулсан, овог язгуур, өвөг дээдсийн, тосгоны, бөө удганы домог гэж хуваасан нь бий.

Тус өгүүлэлд төр улсыг байгуулсан домгоос танилцуулахын зэрэгцээ солонгос домгийн дүр төрхийг тодруулан гаргахыг зорив.

Тангүний домгийн тухай ойлголт

Төр улс үүсгэн байгуулсан тухай домгууд гол төлөв “Гурван улсын нөхсөн судар” зэрэг сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд “Тангүний домог”, “Жү Муны домог” нь Солонгосын хойг нутгийн, “Паг Хёг Госэгийн домог”, “Ким Сү Ругийн домог”-ийг өмнөд зүгийн домог гэж хуваадаг. Эдгээр домог нь төр улсыг үүсгэн байгуулагчдын домог учраас улс үүсгэн байгуулах ур чадварыг нээн үзүүлэхийн хамт хааны гэр бүлийн овог язгуур угсаа гарал нь домогзүйн шинжийг хадгалж байдаг. “Тангүний домог” солонгос домгийн төлөөлөл болохоос гадна төр улс байгуулсан домгуудын охь дээж гэж үнэлэгдсээр иржээ.

“Гурван улсын нөхсөн судар”-аас эхлээд “Эзэд хаадын магтуу”, “Ынжэ Шижү”, “Сэжун Шиллуг Жирижи”, “Зүүн улсын нэвтэрхий толь”, “Гювон Сахуа” зэрэгт тэмдэглэгдсэн боловч “Гурван улсын нөхсөн судар”-т бичигдсэнээр өргөн тархсан юм. Энэхүү “Тангүний домог”-ийн агуулгыг хураангуйлж үзэцгээе.

Хуан Инийн хүү Хуан Үн тэнгэрийг орхиж хүн төрөлхтний ертөнц рүү очих хүсэл дүүрэн байдаг.

Хуан Инь хүүгийнхээ хүслийг таашаан дэмжиж, гурван зүйлийг өгөөд тэдгээрийг захируулахаар явуулна.

Салхи, бороо, үүлийг захирахын зэрэгцээ сайн муу зүйлийн ажлыг эрхлэн шийтгэх эрх мэдлийг өгчээ. Хуан Үн баавгай бар хоёрт сармис ба агь өвс идүүлж зуун хоног нар үзэж болохгүй хориг цээрийг тогтооно. Баавгай түүний хэлснийг биелүүлж эмэгтэй хүний дүрд хувилан Хуан Үнтэй гэрлэнэ. Тэр хоёрын дундаас Тангүн төрснөөр Пён Ян Сонд нийслэлээ байгуулж Чусон гэж нэрлэв.

Тангүн хаан улсаа төвхнүүлсний 1500 жилийн дараа 1908 насыг наслаж, Асадар гэгч газар бүгж суусаар уулын савдаг болно.

1-3 дугаар хэсэгт Хуан Инь, Хуан Үн нарын эцэг, хүүгийн харилцаанд түшиглэн тэнгэр газрын хэлхээ холбоог тайлбарласан байна. 4-6 дугаар хэсэгт Хуан Иньтэй харилцаа холбоо тасарч гагцхүү хүн төрөлхтөнтэй харилцаж буйг тусгажээ.

Сүүлчийн 6-7 дугаар хэсэгт Тангүн хаан улс орныг удирдан зохицуулах, түүний нас барсны дараах үйл явдлууд хамаарна. Иймээс эл домгийг

Хуан Инь, Хуан Үн хоёрын тэнгэрийн шүтэлцээ хамаарал, Хуан Үн Хүн Зон газар дэлхийтэй харилцах, улс орныг удирдан залсан үйл явдал гэж 3 хувааж болно. Энэ домогоос Хуан Инь-Хуан Үн-Тангүн нарын харилцаанаас гурван том удирдагчийн дүр төрхийг мэдэж байна. Хуан Инь тэнгэрийг эзэгнэн захирагч ноён, хүү Хуан Үн нь хоёрдмол шинжтэй.

Нэг талаас тэнгэр эзний хүү боловч нөгөө талаас газар дэлхий дээр амьдардаг. Газар дэлхийн амьдралыг хүссэнээр эцгийн зөвшөөрлийг олж, Тэбээг Сан уулын Шин Дан Сүг уруудаж Шинши хэмээх газарт суурьшжээ. Гурав дахь их удирдагч Тангүн нь дэлхийг удирдагч хаан юм. Ийм гурван удирдагчидын тухай бүтээлийг Солонгосын Тангүний домгоос харж болох ба солонгос уран зохиолын төрөлх хэв шинжийг хадгалсан болохыг таниулж буй хэрэг юм.

Хуан Үн тэнгэрээс бууж ирэхдээ гурван зүйлийг авч ирдэг. Энэ нь тэнгэрийн эрх хүчийг бэлгэдсэн эд зүйл юм. Тиймээс салхи, бороо, үүлийг эрхэндээ байлгана. Хүний аж амьдрал, амь зуулгын эх үндэс болсон газар тариалангийн ажил эрхлэхэд хамгийн хэрэгцээтэй тэдгээр зүйлс байдаг. Мөн газар дэлхийн сайн, муу үйлийн ажлыг эрхлэн шийтгэж байдаг нь тэнгэр эзнээс газар дэлхийд соёрхон хүртээж буй хууль ёс, эмх журмын зайлшгүй үйлдэл болно.

Эндээс үзвэл Хуан Үн газар дэлхийд бууж ирсэн нь эцгийн заавраар тэнгэрийн журам ёсыг газарт шилжүүлэн авчирсан гэдгээр ойлгож болно. Сонирхол татаж буй өөр нэг дүрслэл нь баавгайн дүрийн хувиралт юм. Баавгай, бар хоёр хүн болохын тулд Хуан Үнээс үргэлж мөргөн гуйна. Хуан Үн тэдэнд хорио цээрийг чандлан сахихыг хэлнэ.

Домог зүйд хорио цээрийн элемент нь хүслээ биелүүлэхийн тулд зайлшгүй сахих ёстой зүйл болдог. Баавгай үгийг нь чандлан сахиснаар хүний төрхийг олж, бар хоригийг зөрчсөнөөр хүн болж чаддаггүй. Эндээс ажиглавал баавгай болон бар нь балар эртний тотем дүр юм.

Тотем нь домогзүйн бэлэгдэлтэй уялдаа холбоотой. Хуан Үн, баавгай, бар гурвыг түүхэн уялдаа холбооноос харвал, юуны өмнө бар, баавгайг тотем язгуур овог гэж үзэх үндэстэй.

Тэднийг Солонгосын хойгт оршин суугч өвөг дээдсийн уг гарал гэж тооцох нь бий. Тиймээс

Хуан Үн нь Солонгосын хойгт ирж суурьшсан цагаач язгуур овог мөн. Цагаачлан ирсэн овгийн толгойлогч Хуан Үн Солонгосын хойгийг эзэгнэхийн тулд уугуул нутгийн баавгай бар хоёрын нэгтэй хуримлах ёстой болсон тул тэдний дунд өрсөлдөөн зохиоход баавгай шалгарчээ. Баавгай, бар хоёрыг харьцуулахдаа баавгайн тэсвэртэй, шаргуу зан чанарыг барын аймшиггүй зоригт, ардаг ярдаг чанартай сөргүүлэн үзүүлжээ.

Баавгайг эрхэмлэн үзсэнийг нягтлавал, өөрсдийн өвөг дээдсийг баавгайнаас гаралтай гэсэн таамаглалын тайлбар болно. Хуан Үн болон баавгай гаралтай бүсгүй нар ийнхүү учраад төрсөн хүүхэд нь Тангүн юм.

Тангүний хорвоод мэндэлсэн хэсгийн өгүүлэмжийг орхиод дараагийн хэсэгт анхаарлаа хандуулвал тэнгэрээс бууж газарт ирэхэд эхнэрийг нь хүний төрхөнд хувиргаж хуримлуулж буй хэсэг, тэнгэр эцэг, газар эхт гэр бүлээс төрсөн Тангүн эртний Чусон улсыг үүсгэн байгуулж, оршин тогтноулсан хэсэг, насан эцэслээд уулын савдаг болсон хэсгүүд тухайн домгийн гол цөм хэсгийг бүрдүүлнэ. Тэнгэр эзэн газрын дагинатай хуримлаж байгаа

Бэлэгдлийн дүр дүрслэлийг бусад домог үлгэрээс ч харж болох тул солонгос домог зохиолын хэвшмэл цогц дүрслэлд тооцож болно. Тангүн эртний Чусон улсыг үндэслэн байгуулж улсаа төвхнүүлсний дараа уулын савдаг болдог. Ийнхүү Тангүний тэнгэр заяат байдлыг дахин онцлон бататгаж байна. Тангүн тэнгэрээс гаралтай тул нас барахдаа төрөлх тэнгэрийн орондоо буцаж байгаагаар дүрслэгдэнэ.

Тиймээс гол баатар тэнгэрээс заяагдаж, газар дэлхийд амьдарч байгаад тэнгэртээ буцах үзэгдэл, ийм уран сэтгэлгээг илэрхийлсэн дүрслэлүүдийг Ази Европын аль ч газрын зохиол бүтээлээс харж болох түгээмэл шинжтэй юм. Сүүлийн үеийн үргэлжилсэн үгийн зохиолд энэхүү мотефийг өргөн ашиглахаар барахгүй гол бүрэлдэхүүн болгосон нь харагддаг.

Жү Муны домгийн тухай ойлголт

“Жү Муны домог” нь эртний Күрөгийн өвөг эцэг Жү Муны тухай домог юм. Энэ домгийг “Нэр нэгт домог” гэж нэрлэдэг бөгөөд Пүё улсын олон язгуур овгийн нийтлэг шинжийг агуулсан энгийн нэр томъёо юм. Жү Мунь эртний Күрөг үндэслэн байгуулж улмаар хүчирхэгжиж, Зүүн

хойд Азийн эзэнт гүрэн болтлоо хөгжих үед Пүёгийн язгууртны дунд уламжлан яригдсан эл домгийн агуулгыг олон янзаар дэлгэрүүлсэн нь харагдана. Эл домог эртний Күрөгийн 19 дэх их хаанд зориулсан хөшөө дурсгалаас гадна “Нунхён”, “Хүхансо”, “Вүй улсын бичиг”, “Тансо” зэрэг Хятад түүхэн сурвалж, “Гурван улсын түүх”, “Гурван улсын нөхсөн судар”, “Зүүн улсын Исангүк түүвэр”, “Ынжэ Шижу” зэрэг солонгосын олон сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг.

XII зууны Курёгийн үед бичгийн түшмэл байсан Игюбу эл домгоос сэдэвлэн “Тунмёнванпён” гэсэн шүлэг туульсыг бичжээ. “Зүүн улсын Исангүк түүвэр”-ийн “Тунмёнванпён” нь ханзаар бичсэн бүтээл бөгөөд өргөн утга агуулгыг шингээсэн байдаг юм. Тэрхүү домгийн агуулгыг хураангуйлан үзье.

Чон Жэ хааны хүү Хэ Му Сү, Ха Пээгийн охин Ю Хуаг гэрлэн туяагаар жирэмслүүлнэ.

Жү Мун өндөг болж төрсөн учраас хаягдахад хүрэхэд араатан амьтад хамгаална.

Жү Мун Пүё улсын хааны хөвгүүдийн атаа жөтөө, хардлага хавчлагаас зугтаж Пүёгоос явна. Жү Мун загас жараахайн тусламжтай голыг гатална. Жү мун Сун Ян хааныг ялж улсаа байгуулна. Жү Мун нас эцэслэж тэнгэр лүү одно. Жү Муны хүү Юри эцгийгээ хайна.

Эхний хэсэг нь Хэ Му Сү болон Ю Хуагийн гэрлэлтийн сэдэв: Хэ Му Сү нь тэнгэрийн эзэн Чон Жэгийн хүү, Ю Хуа нь газрын эзэн Ха Пээгийн охин юм. Тэнгэрийн эзэн усны дагинатай гэрлэснээр ирээдүйд төрөх баатар эрийн ариун нандиныг бэлгэдсэн бөгөөд тэрхүү удмын уг гарлын эрхэм дээд эзэнлэг чанарыг илтгэн харуулжээ. Хэ Му Сү болон Ю Хуагийн хуримлалт нь “Тангүний домог”-той харьцуулбал, Хуан Үн баавгай гарвалтай бүсгүйтэй хуримласантай адил тэнгэр эзэн газрын эзний хүч нэгдэж буйг харуулна.

Хоёрдах хэсэг нь Жү Муны хорвоод мэндэлсэн нь: Түүний мэндэлж буй ер бусын шинж нь нарны гэрэл үзэнгүүт хэвлийд олдож өндөг болж төрсөн, араатан жигүүртэн түүнийг хамгаалж байгаа өгүүлэмж юм. Ер бусаар хэвлийд олдож төрөх дүрслэл баатарлаг зохиолд элбэг тохиолддог зүйл бөгөөд Жү Муний баатарлаг чанарын урьдчилсан болзолт нөхцөл ажээ. Манай улсын үлгэр

зохиолд өндөгнөөс төрсөн дүрслэгдэхүүн байнга тааралддаг зүйл бөгөөд энэ нь нартай холбоотой сэтгэлгээтэй уялдаатай юм.

Гуравдах хэсэг Жү Мун эрийн цээнд хүрч Пүё улсаас зугтан гарсан тухай: Энэ нь Пүё улсын хаан хөвгүүдийн тэмцэл, хүлэг морио сонгосон, улс орныг бүтээн байгуулахад оролцсон гавьяа зүтгэлт түшмэдээ олсон хэмээх гурван зураглалаас бүрэлдэж байна. Хэ Му Сү болон Ха Пээг, Жү Мун болон Пүё улсын хаан хөвгүүд, Жү Мун ба Сун Ян нарын тэмцэл нь гол баатар дахин амьдрахын төлөөх тэмцэл байдаг. Тэмцэл бүрд далдын ид шидийн хүчийг гарган үзүүлнэ. Жү Мун хүлэг морио олсон хэсэг, Пүё улсаас зугтах үед загас жараахай тусалж гол гаталсан зэргээс Жү Муны баатарлаг чадварыг олж харж чадна.

Дөрөвдэх хэсгийн агуулга нь Жү Муны улс байгуулсантай холбоотой өгүүлэмж: Шинэ улс байгуулах үед арвайн үрийг амандаа зууж авчирсан тухай дүрслэл нь эл домог үүсэх цаг үест газар тариалангийн ажил эхэлж байсантай хамааралтай утга билээ. Үүнийг ан гөрөө эрхэлдэг байсан нийгэмд нум сум, морь зэргийг дүрслэн харуулж байгаатай харьцуулж ойлгох нь зохимжтой. Тодруулбал, Жү Мун нам дор газарт улс байгуулсан нь суурьшмал нийгэм, арвайн үрийг олж байгаа нь ан гөрөө эрхэлж байсан нийгмээс газар тариалан эрхэлдэг нийгэм рүү шилжсэн өөрчлөлтийн утгыг тус тус илтгэж байна. Өөрөөр хэлбэл үржил шимтэй газрыг хайж нам дор газарт очиж, газар тариалан эрхлэн суурьшаад тэндээ захирагч нь болсон утгыг үзүүлжээ.

Тав дах нь Жү Мун Пирю улс руу довтолсон тухай: Улс орноо цэцэглүүлэн хөгжүүлсэн тухай дүр зураг юм. Гол усыг эзэгнэн захирч Сун Ян хааныг дагаар оруулсан хэсэг бол үерийн усыг захирч суудаг Хятадын Ү хааны үйл хэрэгтэй холбогддог. Үүгээрээ Жү Мун газар тариалан эрхэлж эзэн болж чадна гэдгийг харуулжээ.

Зургаа дах нь Жү Мун тэнгэрт одсон нь: Жү Мун Пирю улсыг нэгтгэн сүр хүчээ өндөрт өргөж, орд өргөө бариулж, эрх баригчийн нэр төрийг бадраан арван есөн жилийн турш улсаа төвхнүүлсний эцэст тэнгэрт халина. Жү Мун нас бармагц тэнгэр лүү явж байгаа нь Тангүнийхтэй адил тэнгэр язгуурлаг шинжийг үзүүлжээ.

Долоо дахь нь хаан ширээ залгамжлах нь: Юри хаан ширээг залгамжлахын өмнө Жү Муны сорилыг давах хэрэгтэй болдог. Энэ нь улс орныг

удирдах ур чадварын шалгалт юм. Юри шалгалтыг давж Күрө улсын хоёр дахь хаан ширээнд заларч чадна.

Иймээс эл домог нь Хэ Му Сү-Жү Мун-Юри гэсэн гурван их эзний тухай бүтээл болно. Дээр өгүүлсэнчлэн эртний Күрөгийн “Жү Муны домог” нь баатарлаг туульсын шинжтэй бүтээл юм.

Эртний Күрөгийн өвөг Жү Мун тэнгэр эцэг, газар эхээс гаралтай боловч өндөг болж төрсний улмаас хээр хаягдана. Жирийн хүнээс онцгой тэнгэрлэг шинжтэй тул өсөх насандаа олон бэрхшээл туулсан ч ер бусын тус дэмжлэгийг авч эгэлгүй авьяасаар тэмцлийн оргилд хүрч хаан ширээг залгамжилдаг. Жү Муны амьдрал баатарлаг эрийн намтар түүхтэй адил байна.

Дэлхийн баатарлаг туульсын үндсэн хэв маягийн болсон баатар эрийн намтар түүхийн товчоон нь эрхэм дээд угсаа гарал хийгээд ер бусын байдлаар хорвоод мэндлэх, онцгой авьяас эзэмших, бага насандаа бусдад хаягдах, авран хамгаалагчтайгаа уулзах, эрийн цээнд хүрмэгц аюултай нүүр тулах, аюулыг давснаар ялалтанд хүрэх зэрэг хэв маягийг хадгалах төдийгүй дундад зууны дараах манай үргэлжилсэн үгийн зохиол бүтээлд уламжлагджээ. Иймээс “Жү Муны домог”-ийг баатар эрийн намтар түүхийг харуулсан үргэлжилсэн үгийн зохиол бүтээлийн үндсэн загвар гэж тооцож болно.

Ким Сү Ругийн домгийн тухай ойлголт

“Ким Сү Ругийн домог” нь Кая улсын өвөг Ким Сү Ругийн тухай юм. Кая улс нь МЭӨ 562 он хүртэл манай улсын Кён Сан Ду буюу баруун зүгт оршиж байсан улсыг хэлнэ. МЭӨ болон манай эринд Кённам Хэ анжидэд төмөрлөгийн соёл хөгжихийн хэрээр нийгмийн орчин сайжирч жижиг улсууд бий болж эхэлсэн бөгөөд тэдгээр нь зургаан Кая улс юм. “Гурван улсын нөхсөн судар”-т тэмдэглэгдсэн “Ким Сү Ругийн домог” нь үүнтэй хамааралтай домог болохын хувьд агуулгыг товчлон хэсэг тус бүрээр утгыг ажиглан судалж байна.

Нэр төр бүхий есөн толгойлогч амьдардаг байв. Тэнгэрээс илгээсэн өндөгнөөс Ким Сү Ру мэндэлнэ. Ким Сү Ру болон Тал Хэгийн тэмцлийг харуулна. Ким Сү Ру Аюута улсын гүнж Хо ван Угтай хуримлана. Ким Сү Ру улсаа үндэслэн байгуулж 157 насандаа өөд болно.

Зохиолын эхний хэсэг дэх Ким Сү Руг төрөхөөс өмнөх есөн толгойлогчийн аж амьдралын

дүрслэлээр Ким Хэ нутагт амьдарч байсан уугуул иргэдийн амьдралыг харуулжээ. Хоёр дахь хэсэгт Ким Сү Ругийн хорвоод мэндэлсэнтэй холбоотой есөн толгойлогч цугларч, тэнгэрт тахилга өргөх үед тэнгэр эзэн тэдэнд хааныг явуулдаг. Улаан ягаан өнгийн олс тэнгэрээс газарт буун ирсэн дүрслэлээр Ким Сү Ру тэнгэрээс заяатай болохыг заана.

Ялангуяа улаан ягаан олс, алтлаг хайрцаг, улаан өлгий зэрэг нь нарны билэгдлийг хадгалж, нарны эзний сүр хүчийг илтгэнэ. Түүнчлэн өндөгнөөс төрсөн мотөф дүрслэл нь “Жү Муны домог”-ийн адил домог зохиолд нийтлэг үзэгддэг тусагдахуун төдийгүй гол дүрийн тэнгэрийн гарал хийгээд баатарлаг шинжийг тодотгоно.

Өндөгнөөс төрөөд арав хоносны дараа гурван сарын арван таванд хаан ширээнд заларсан тухай дүрслэлээс бусадтай эгнэшгүй ер бусын баатарлаг болохыг нь харж болно. Гурав дахь хэсэгт Тал Хэтэй хийсэн тэмцлийн тухай өгүүлнэ.

Тал Хэ буюу Сог Тал Хэгийн дүрийг Сог овгийн өвөг дээдсийн домог гэж үзсээр иржээ. Ким Сү Руг хаан ширээнд заларсны дараа түүнээс ширээг нь булаахаар тэмцэлддэг. Тэдний зүсээ хувирган хүч чадлаа сорьж байгаа хэсэг “Жү Муны” домог дахь Хэ Му Сү болон Ха Пээгийн дунд өрнөсөн тэмцэлдээнтэй адилаар дүрслэгджээ.

Ким Сү Ругийн ялалтаар төгсөх бөгөөд энэ хэсгээр гол баатрын тэнгэр хүчит баатарлаг чанарыг дахин бататган харуулсан гэж үзэж болно. Дөрөвдэх хэсэгт Ким Сү Ругийн хуримыг харуулжээ. Хо Хуан Уг нь Аюута улсын гүнж бөгөөд түүний эцэг эхийн зүүдэнд Хуан Чон Санжэ ирж, охиноо Караг улсын Ким Сү Ру хааны хатан болгон явуул гэдэг.

Хо Хуан Уг язгуурлаг хатан хүний шинж бүрдсэнийг Ким Сү Ругтай хуримлах зан үйлд тод томруунаар дүрсэлжээ. Хо Хуан Уг далай гатлан ирдэг дүрслэл нь хамгийн сонирхолтой. Энэ нь Солонгосын хойгоор шилжин суурьшиж ирсэн овог аймгийн талаар өгүүлж буй хэрэг юм.

Хо Хуан Уг нь завинаас бууж ирэхдээ торгон өмдөө тайлж, уулын эзэнд өгдөг нь эмэгтэй гэдгээ батлан харуулсан үйлдэл болохын зэрэгцээ хуримын болзолт үйл зан гэж хэлж болох юм. Ким Сү Ру нь Ким овгийн өвөг, Хо Хуан Уг нь Ким Хэ Хо овгийнх учраас овог хооронд хуримлаж болохгүй ёстой аж. Тавдахь хэсэгт Ким Сү Ругийн ажил үүргийн талаар дүрсэлсэн байна. Албан ажил

болон нэр цол зэрэг бүх тогтолцоог шинэчилж улсынхаа үндэс суурийг тогтоон, улмаар ард иргэдийн амар амгалангийн төлөөх түүний гавьяа хийгээд ажилч хичээнгүй зан төрхийг дүрслэн харуулжээ.

Энэ хэсгийн анхаарал татах нэгэн сонин дүрслэл нь хаан хатны насан хутгийг олох үйл явдал билээ. Ким Сү Руг нас барсны дараа тэнгэрт одсон тухай огт дурдагддаггүй бөгөөд шарилыг нь газарт оршуулах ёслол үйлдэж байгаа тухай гарна. Энэ нь тэнгэрт одсоны дараа бунхан үлдээдэг “Жү Муны домог” эсвэл “Паг Хёг Го Сэгийн домог”-оос ялгагдах онцлог юм.

Ким Сү Ру тэнгэрийн элч эзэн гэхээс илүү хүн төрөлхтөний жам ёсыг дагаж байна. Солонгосын “Тангүний домог”, “Жү Муны домог” нь тэнгэрийн эрчүүд газар болон усны эздийн охидтой холбоо тогтоож, хуримлах зан үйл бодитой дүрслэгдэхээр барахгүй хаан язгууртан хорвоод мэндлэх, хаан ширээг эзлэх гэх зэргээр үргэлжилнэ.

Тухайлбал, хурим-мэндлэлт гэсэн хэлбэрээр дүрслэгдэнэ. Гэтэл “Ким Сү Ругийн домог”-т эзэн эхэлж мэндлээд, дараа нь хуримладаг. Дахин хэлэхэд өмнөхөөс тэс өөрөөр мэндлэлт-хурим гэсэн бүтцийн дагуу зохиогджээ. Энэхүү ялгаанаас өмнөхийг умард зүгийн домог, дараагчийнхыг нь өмнөд зүгийн домог үлгэр гэж хуваан ангилдаг. Дашрамд дурдахад, тэнгэрээс бууж ирсэн тухай дүрслэл, өндөг болж төрсөн тухай үйл явдал, тэнгэр эцэгтэй газар эхтэй гэсэн яриа зэргээс үзвэл солонгосын домог зохиол нь голдуу нэгдмэл нийтлэг зан төрхийг илтгэдэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

И Жи Ён. (2000). *Солонгос улс төр байгуулсан домгийн нүүр төрх ба ойлголт*. Сөүл: Ворин.

И Жи Ён. (2003). *Солонгос домгийн тухай яриа*. Сөүл: Сагүнжа

Жу Хён Сол. (2006). *Манай домог зохиол дахь оньсого*. Сөүл: Хангёрэ хэвлэх үйлдвэр

Кан Дён Хаг. (2002). *Солонгос аман зохиолын тухай ойлголт*. Сөүл: Ворин

Ким Хон Сон. (1994). *Солонгосын ертөнцийн үүсэл гарлын домог*. Сөүл: Кирбод

Со Дэ Сог. (1997). *Солонгос домог*. Сөүл: Жибмүндан

Су Жэ Ён. (1989). *Солонгос үлгэр зохиолын судалгаа*. Сөүл: Суншил хэвлэлтийн газар

Хён Юн Жүн. (1992). *Бөө мөргөлийн домог ба эх сурвалжийн домог*. Сөүл: Жибмүндан

Орчуулсан: Д.Жигзмаа, магистр, МУБИС